

ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНД ТӨСЛИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Цахим эрүүл мэнд” Төслийн удирдах хороо(ТУХ)-ны 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хурлаар “Төслийн үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө” батлагдан хэрэгжүүлэн ажилласан. Харин энэ оны 5 дугаар сард “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтэд Дэлхийн банкнаас дунд хугацааны үнэлгээ хийж, төслийн бүтцийг өөрчлөлт хийж, 5 бүрэлдэхүүн хэсгийг 3 бүрэлдэхүүн хэсэг болгон үйл ажиллагааг нэгтгэснийг үндэслэн ТУХ-ны энэ оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хурлаар “Төслийн үйл ажиллагааны 2018 оны сүүлийн хагас жилийн төлөвлөгөө”-г баталсныг Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан болно.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйгээр төслийн арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл 2018 онд нийтдээ 57 ажил төлөвлөснөөс:

- “үр дүнтэй”– (90-100 хүртэл хувь) хэрэгжсэн ажил - 21
- “тодорхой үр дүнд хүрсэн”-(60-89 хүртэл хувь) хэрэгжсэн ажил - 15
- “эрчимжүүлэх шаардлагатай”- (0-30 хүртэл хувь) хэрэгжсэн ажил - 2
- “үнэлэх боломжгүй” буюу Дэлхийн банкны дунд хугацааны үнэлгээгээр төслийн бүтцийн өөрчлөлтөд орж хойшлогдсон буюу хасагдсан ажлууд - 17 тус тус байна.

2018 онд “Цахим эрүүл мэнд” төслийн төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлт 84.1 хувь байна.

1.1.1. Цахим эрүүл мэндийн олон улсын урт хугацааны зөвлөхийн үйлчилгээ авах (бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.2.1-д орно)

Цахим эрүүл мэндийн олон улсын урт хугацааны зөвлөх Димитрис Калогеропоулос энэ оны 3, 9, 10 дугаар сард ТХН дээр ирж ажиллаж, дараах стандарт журмын төслүүд боловсруулсан. Үүнд:

- Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэлийн журам, стандарт,
- Өвчний цахим түүхийн стандарт,
- Өвчтөний цахим шилжүүлгийн журам,
- Өвчтөний хураангуй мэдээллийн журам,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг тодорхойлох стандарт.

Мөн ЭММСП-ын ОУНТ-ын ажлын удирдамж боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Төслийн хүрээнд боловсруулах стандартын төлөвлөгөөг 2018-2021 оны байдлаар гаргасан. Дотоодын 3 зөвлөхийн ажил үүргийн хуваарийг тодорхойлж, Иргэний эрүүл мэндийн цахим бүртгэл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эписойдын талаар хэлэлцүүлэг хийсэн. Эрүүл мэндийн статистикийн мэргэжилтнүүдэд зориулсан цахим эрүүл мэндийн сургалтанд "Цахим эрүүл мэндийн стандарт, журам боловсруулах ажлын явц" сэдвээр илтгэл тавьж хамтран ажилласан.

1.1.2. *Энтерпрайз архитектурын програм хангамжийн лиценз худалдан авах (бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.4.3)*

Тус ажил нь Энтерпрайз архитектур ба харилцан үйлчлэлцлийн хүрээг боловсруулах байгууллага сонгогдсоны дараа техникийн тодорхойлолт нь гарах тул Дэлхийн банкны зөвлөмжөөр бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу 2019 оны эхний хагаст хийхээр хойшлуулсан.

1.1.3. *Энтерпрайз архитектурын олон улсын зөвлөх үйлчилгээ авах (бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.4.1)*

ЭМЯ-тай байгуулсан гэрээнийхээ дагуу төслийн Энтерпрайз архитектурын олон улсын зөвлөх 2018 онд Монгол Улсад дөрвөн удаа ирж, нийтдээ 4 сарын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болно. Бусад хугацаанд зайнаас ажиллаж байсан бөгөөд ТХН-ийн ажилтнуудаас явуулж байсан цахим шуудан, skype холбоогоор тогтмол харилцан ажилласан.

1.1.4. *Энтерпрайз архитектур болон харилцан үйлчлэлцлийн тогтолцоог хөгжүүлж, хэрэгжүүлэх (Бизнес архитектур, өгөгдлийн архитектур, хэрэглээний архитектур, технологийн архитектур) үйл ажиллагааг Олон улсын нээлттэй тендер(ОУНТ)-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх (бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.4.2)*

Цахим эрүүл мэнд төслийн нэгж Энтерпрайз архитектур болон харилцан үйлчлэлцлийн хүрээг боловсруулах олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичгийн төслийг 2017 оны 10 сард боловсруулж, тендер шалгаруулалтын үнэлгээний хороо ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 2 сарын 9-ний өдрийн А/33 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, 2018 оны 2 сарын 12-нд хуралдаж тендерийн баримт бичгийг батлан, Дэлхийн банкинд илгээсэн. Тендерийг зарлах зөвшөөрлийг Дэлхийн банк 2018 оны 2 сарын 14-нд олгож, тендер 2018

оны 3 сарын 23 хүртэл зарласан. Үнэлгээний хороо тендерийн үнэлгээг 2018 оны 4 сарын 6-7 болон 9-ний өдрүүдэд хийж, үнэлгээний тайланг Дэлхийн банкинд 2018 оны 4 сарын 12-нд илгээсэн. Дэлхийн банк гэрээ байгуулах эрх олгосон байгууллага шаардлага хангаагүй гэж үзсэн тул үнэлгээний хороо дахин 2018 оны 5 сарын 9-ний өдөр хуралдаж, бүх тендерээс татгалзах дүгнэлттэй үнэлгээний тайланг 2018 оны 6 сарын 18-нд баталсан. Энтэрпрайз архитектур ба харилцан үйлчлэлцэлийн хүрээг боловсруулах тендерийг ЭММСП-тай уялдуулж явах зөвлөмжийг 2018 оны 5 сард хийгдсэн төслийн дунд хугацааны үнэлгээгээр гаргаж, тендерийг 2018 оны 12 сараас эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Энтэрпрайз архитектур ба харилцан үйлчлэлцэлийн тогтолцоог боловсруулах тендерийг шинэчлэн засварлаж, ЭММСП-ын тендерийн хүрээнд хийгдэх ажлууд, түүнд зарцуулах төсвийг нь хасаж тооцсон тендерийн баримт бичгийн анхны хувилбарыг нь боловсруулан 2018 оны 9 сарын 6-ны өдөр Дэлхийн банкинд хүргүүлсэн.

1.2.1. Эрүүл мэндийн өгөгдлийн дотоодын зөвлөх хөлслөх үйлчилгээ авах

Дотоодын зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороо ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2 дугаар сарын 13-ны өдрийн А/35 тоот тушаалаар байгуулагдаж, үнэлгээний хорооны 2-р сарын 21-ний өдрийн хурлаар дотоодын зөвлөхөд тавигдах шаардлагыг шинэчлэн баталсан. Дэлхийн банкны 3 дугаар сарын 15-нд зөвшөөрөл олгож, 3 дугаар сарын 16-наас “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудаар зар түгээж, 3 дугаар сарын 29-нд 3 горилочоос материал хүлээн авсан. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд 2018 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн А/170 тоот тушаалаар өөрчлөлт орж, 5 дугаар сарын 11-ний өдөр Үнэлгээний хороо хуралдан Л.Хандсүрэнг сонгон шалгаруулсан. Сонгон шалгаруулалтын үр дүнгээ Дэлхийн банкинд 5 дугаар сарын 31-ний өдөр мэдэгдэж зөвшөөрөл авч, сонгон шалгарсан Л.Хандсүрэн 2018 оны 6 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн гэрээгээр ажиллаж эхэлсэн. Гэрээний дагуу төлөвлөсөн ажлууд хийгдэж байна.

1.2.4.1. Цахим эрүүл мэндийн хуулийн дотоодын зөвлөх хөлслөх, үйлчилгээ авах

Дотоодын зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороо ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 3 дугаар сарын 26-ны өдрийн А/92 тоот тушаалаар байгуулагдаж, үнэлгээний хорооны 3-р сарын 27-ны өдрийн хурлаар дотоодын зөвлөхөд тавигдах шаардлагыг шинэчлэн баталсан.

Дэлхийн банкны 4 дүгээр сарын 19-нд зөвшөөрөл олгож, 4 дүгээр сарын 24-нөөс “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудаар зар түгээж, 5 дугаар сарын 8-нд 6 горилогчоос материал хүлээн авсан. Үнэлгээний хороо 5 дугаар сарын 11-ний өдөр хуралдан Н.Энхцэцэгийг шалгаруулсан. Дэлхийн банк зөвшөөрөл өгсөний дагуу гэрээ байгуулан 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн ажиллаж эхэлсэн. Гэрээний дагуу төлөвлөсөн ажлууд хийгдэж байна.

1.2.4.2. Эрүүл мэндийн өгөгдлийн стандарт боловсруулах дотоодын зөвлөхийн үйлчилгээ авах *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.2.3)*

Эрүүл мэндийн өгөгдлийн стандарт боловсруулах дотоодын зөвлөх нь Эрүүл мэндийн салбарт нэвтрүүлж, нутагшуулах шаардлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим эрүүл мэндийн стандартуудын жагсаалт, хамрах хүрээг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг боловсруулан ТХН-д танилцуулсан. Олон улсын “Эрүүл мэндийн мэдээлэл зүй-Тусламж үйлчилгээ үзүүлэгчийн ялган таних-ISO/TS-27527”, “Эрүүл мэндийн мэдээлэл зүй-Үйлчлүүлэгчийг ялган таних-ISO/TS-22220” Техникийн тодорхойлолтын нийтлэг шаардлагуудыг орчуулан өөрийн орны онцлогт нийцүүлэн өөрчлөн боловсруулсан. “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних журам”, “Хэвтэн эмчлүүлэгчийн тэмдэглэл”-ын загвар журам, “Амбулаторийн эмчийн үзлэгийн тэмдэглэл”, “Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх”-ын стандартуудыг боловсруулан “Цахим эрүүл мэндийн стандартад санал дүгнэлт өгөх техникийн ажлын хэсэг”-ийн хурлаар хэлэлцүүлсэн. “Иргэний Эрүүл мэндийн цахим бүртгэлийн журам”, “Цахим шилжүүлгийн журам”-ын анхны төслийг боловсруулсан.

1.2.4.3. Эрүүл мэндийн өгөгдөл солилцох стандартын дотоодын зөвлөх хөлслөх, зөвлөхийн үйлчилгээ авах

Дотоодын зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороо ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 3 дугаар сарын 26-ны өдрийн А/92 тоот тушаалаар байгуулагдаж, үнэлгээний хорооны 3-р сарын 27-ны өдрийн хурлаар дотоодын зөвлөхөд тавигдах шаардлагыг шинэчлэн баталсан. Дэлхийн банкны 4 дүгээр сарын 9-нд зөвшөөрөл олгож, 4 дүгээр сарын 10-наас “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудаар зар түгээж, 4 дүгээр сарын 23-нд 2 горилогчоос материал хүлээн авсан. Үнэлгээний хороо 5 дугаар сарын 11-ний өдөр хуралдан О.Мөнхбадралыг сонгон

шалгаруулсан. Сонгон шалгаруулалтын үр дүнгээ Дэлхийн банкинд 5 дугаар сарын 31-ний өдөр мэдэгдэж зөвшөөрөл авч, сонгон шалгарсан О.Мөнхбадрал 2018 оны 6 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн гэрээгээр ажиллаж эхэлсэн. Гэрээний дагуу төлөвлөсөн ажлууд хийгдэж байна.

1.2.5. Эрүүл мэндийн өгөгдлийн тайлбар толь боловсруулах олон улсын нээлттэй тендер(ОУНТ)-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх ажил *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.2.7)*

Эрүүл мэндийн өгөгдлийн толь бичгийг боловсруулах тендерийн үнэлгээний хороо 3 дугаар сарын 26-ны өдрийн А/91 тоот тушаалаар байгуулагдсан. Үнэлгээний хороо 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр боловсруулсан ажлын удирдамж болон тендерийн баримт бичгийг хэлэлцэж, тодруулга болон саналуудаа Дэлхийн банкинд явуулсан. Дэлхийн банкны зөвшөөрснөөр 9 дүгээр сарын 5-ны өдөр СТЕП системд оруулж, 10-ны өдөр тендер зарласан. 10 дугаар сарын 22-нд тендерийн материал 2 байгууллага ирүүлсэн. Үнэлгээ хийхэд шаардлага хангасан байгууллага гараагүй тул дэлхийн банкинд үнэлгээг 11 дүгээр сарын 27-нд явуулсан. Дэлхийн банкнаас 11 дүгээр сарын 27-нд дахин зарлах шийдвэр ирүүлсэн. Дахин зарлах бэлтгэл ажил ханган ажиллаж байна.

1.2.6. Эрүүл мэндийн өгөгдлийн болон мэдээллийн технологийн стандартуудыг боловсруулах, нутагшуулах ОУНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх ажил *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.2.6)*

Цахим эрүүл мэнд төслийн нэгж Эрүүл мэндийн өгөгдөл болон мэдээллийн технологийн стандартуудыг боловсруулах олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичгийн төслийг 2018 оны 2 сард боловсруулж, тендер шалгаруулалтын үнэлгээний хороо ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 3 сарын 26-ны өдрийн А/91 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, 2018 оны 4 сарын 10-нд хуралдаж тендерийн баримт бичгийг батлан, Дэлхийн банкинд илгээсэн хэдий ч 2018 оны 5 сард төслийн дунд хугацааны үнэлгээ хийгдэхтэй холбогдуулаад тендер зарлах хугацааг Дэлхийн банк хойшлуулж, 2018 оны 7 сарын 18-нд баталж тендерийг 2018 оны 8 сарын 28-нийг хүртэл зарласан. Үнэлгээний хороо тендерийн үнэлгээг 2018 оны 9 сарын 18 болон 10 сарын 4-ний өдрүүдэд хийж, үнэлгээний тайланг Дэлхийн банкинд 2018 оны 11 сарын 12-нд илгээсэн. Дэлхийн банк тендерт оролцогчоос тодруулга авах

зөвлөмжийг ирүүлсний дагуу тодруулгыг тендерт оролцогчоос 2018 оны 12 сарын 11-ний өдөр авч, үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлж гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн. Энэ шийдвэрт Дэлхийн банкнаас зөвшөөрөл авахаар явуулсан ба гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

1.2.7. Зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.2.8)

Цахим эрүүл мэндийн стандартад санал дүгнэлт өгөх техникийн ажлын хэсэг байгуулах тушаалын төсөл боловсруулж, ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 9-р сарын 24-ний өдрийн Б/328 тоот тушаалаар батлагдсан. Стандартын хэлэлцүүлгүүдийг 3 удаа зохион байгуулж, дараах 6 стандарт, журмын төслүүдийг хэлэлцүүлсэн. Үүнд:

1. Эрүүл мэндийн оролцогч талуудын ялган таних журам”,
2. “Иргэний Эрүүл Мэндийн Цахим бүртгэлийн систем байгуулах техникийн шаардлага”,
3. “Хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл”,
4. “Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх”-ийн үндсэн өгөгдлийн бүтэц, техникийн шаардлага,
5. Амбулаторийн эмчийн үзлэгийн тэмдэглэл,
6. Цахим шилжүүлгийн журам.

2.1.1. Портал, эмнэлгийн програм хангамж хөгжүүлэх ажлыг ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ (ЭММСП) боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх Олон улсын нээлттэй (ОУНТ)-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

2.1.2. Портал, эмнэлгийн тоног төхөөрөмж ДНТ-ээр сонгон шалгаруулж худалдан авах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП-ын тоног төхөөрөмж худалдан авах ОУНТ-ийн ажилтай нэгтгэгдсэн.

2.1.3. Өвчтөний веб-портал боловсруулах ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

2.1.4. Дүрс оношилгооны програм боловсруулах ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Салбарын хэмжээний Дүрс архивлах хадгалах систем(ДАХС)-ийг боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд Цахим эрүүл мэнд төслөөс 2017 онд хийсэн суурь судалгаа, төслийн туршилтын эмнэлгүүдийн дүрс оношилгооны мэргэжилтнүүдтэй уулзаж, зөвлөлдөн хэрэгцээ шаардлагыг тодруулсан өгөгдөл мэдээлэл дээр үндэслэн ДАХС-ийг боловсруулж нэвтрүүлэх ажлын удирдамж, системийн архитектурыг эхний байдлаар боловсруулан Дэлхийн банкинд хүргүүлсэн.

2.2.1 ЭММСП-ын програм хангамж хөгжүүлэх ажлыг Олон улсын нээлттэй тендер(ОУНТ)-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

2.2.3. ЭММСП-ын загвар боловсруулах ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх ажил

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

2.2.4. ЭММСП боловсруулж нэвтрүүлэх ажлыг ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

2.2.5 ЭММСП-ын олон улсын техникийн зөвлөх ажиллуулах *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.1.2)*

ЭММСП-ын ОУНТ-ын ажлын удирдамж боловсруулах олон улсын, дотоодын зөвлөхүүдийн үйлчилгээ авах зорилгоор “ЭММСП-ын Олон улсын зөвлөх”, “ЭММСП-ын дотоодын зөвлөх” –ийн ажлын удирдамжуудыг тус тус англи хэл дээр боловсруулан, монгол хэл рүү орчуулсан орчуулгын хамт 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.

2018 оны 5 дугаар сарын 15-наас 19-ний өдрүүдэд Дэлхийн банкны Дунд хугацааны үнэлгээний баг Улаанбаатар хотод ажиллах үеэр шинээр олон улсын зөвлөх авахгүйгээр, төслийн Цахим эрүүл мэндийн олон улсын зөвлөх, Энтэрпрайз архитектурын олон улсын зөвлөхүүдийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ЭММСП-ын ОУНТ-ын ажлын удирдамж, тендерийн баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд оролцуулах нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Төслийн Цахим эрүүл мэндийн олон улсын зөвлөхийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, ажиллуулсан. Цахим эрүүл мэндийн олон улсын зөвлөхийн гэрээнд нэмэлт өөрчлөлтийг холбогдох албан тушаалтнууд, түүний дотор ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр батлуулсан. Төслийн Энтэрпрайз архитектурын зөвлөхийг “ЭММСП-ын үзэл баримтлал”, “ЭММСП-ын анхан шатны тендерийн баримт бичиг” –үүдийн талаарх мэдээллээр хангаж, санал, зөвлөмж гаргах бүрт нь баримт бичгүүд дээр тусгаж ажилласан.

2.2.6 ЭММСП-ын дотоодын техникийн зөвлөх ажиллуулах *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 1.1.3)*

ЭММСП-ын олон улсын болон дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулж өгөхийг хүссэн албан бичгийг Олон улсын болон дотоодын зөвлөхийн ажлын удирдамжуудын хамтаар 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр ЭМЯ-нд хүргүүлсэн. 2018 оны 5 дугаар сарын 15-наас 19-ний хооронд Дэлхийн банкны баг Цахим эрүүл мэнд төслийн дунд хугацааны үнэлгээ хийх үеэр зөвлөхүүдийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг дахин хэлэлцсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс ЭММСП-ын дотоодын зөвлөхийг шалгаруулж ЭММСП-ын тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер шалгаруулсны дараа зөвлөхийг платформын гэрээний хяналт тавихаар үргэлжлүүлэн ажиллуулах санал тавьсан. Дэлхийн банкны баг ЭММСП-ын тендерийн баримт бичгийг боловсруулах ажилд бодит туслалцаа үзүүлэх чадвартай дотоодын зөвлөх олох хэцүү гэж үзсэн бөгөөд энэ үйл ажиллагааг хойшлуулах саналтай байсан. ЭММСП-ын дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь ЭМЯ ТНБД-ын 2018 оны 7 сарын 24-ний өдрийн А/261 тоот тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, ТХН ажлын удирдамжийн төслийг 2018 оны 2018 оны 8 сарын 30-нд боловсруулсан. 2018 оны 5 сард хийгдсэн төслийн дунд хугацааны үнэлгээний үр дүнд төслийн бүтцийн өөрчлөлт

хийгдэж, уг зөвлөхийн сонгон шалгаруулалтыг санхүүжилтийн хэлэлцээрт хийх нэмэлт өөрчлөлт батлагдсаны дараа эхлүүлэх зөвлөмжийг Дэлхийн банк өгсөн. Санхүүжилтийн хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт 2018 оны 10 сарын 1-нд батлагдаж, Цахим эрүүл мэнд төслийн Энтэрпрайз архитектурын олон улсын зөвлөх ажлын удирдамж дээр 2018 оны 11 сарын 16-нд саналаа ирүүлсэн. Үнэлгээний хороо ойрын хугацаанд хуралдаж, зөвлөхийн ажлын удирдамжийг хэлэлцэнэ.

2.2.7. Мэдээллийн технологийн дэд бүтэц бий болгох, засвар үйлчилгээ, техникийн дэмжлэг үзүүлэх дотоодын техникийн зөвлөхийн үйлчилгээ авах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП-ын програм хангамж хөгжүүлэх Олон улсын нээлттэй тендерийн ажилтай нэгтгэгдсэн.

2.3.1. Мэдээллийн технологийн дэд бүтэц (Дүрс архивлах хадгалах систем(ДАХС)-ийн тоног төхөөрөмж худалдан авах, дэмжлэг, засвар үйлчилгээ) хөгжүүлэх үйл ажиллагааг ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

ДАХС боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд системд шаардлагатай тоног төхөөрөмж, өгөгдөл хадгалах серверүүдийн жагсаалт үзүүлэлтүүдийг боловсруулж урьдчилсан байдлаар Дэлхийн банк, ЭМЯ-нд танилцуулсан. Өгөгдөл хадгалах серверүүдийн гол үзүүлэлт, хадгалах өгөгдлийн багтаамжийг туршилтын эмнэлгүүдэд 60ТВ, Үндэсний дата төв дээр байрлах төв серверт 400ТВ байхаар тооцоолон төсөвт суулгасан.

2.3.2. Мэдээллийн технологийн дэд бүтэц (ДАХС-ийн програм хангамж худалдан авах, дэмжлэг, засвар үйлчилгээ) хөгжүүлэх үйл ажиллагааг ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

ДАХС боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд системд шаардлагатай програм хангамж, шийдэл, програм хангамжид тавих шаардлагуудыг боловсруулан ажлын удирдамж, системийн архитектурын эхний хувилбарт тодорхойлон Дэлхийн банкинд хүргүүлсэн болно. ДАХС-д үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс үл хамааралтай ДАХС систем боловсруулах, нэвтрүүлж, хэрэгжүүлэх шийдэл гаргасан.

3.2.2 Эрүүл мэндийн өгөгдлийн програм хангамж ДНТ-ээр сонгон шалгаруулж худалдаж авах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

3.2.4 Цахим эрүүл мэндийн програм хангамжийн техникийн туслалцааны дотоодын зөвлөх ажиллуулах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

3.2.9 Цахим эрүүл мэндийн хэрэглээний тоног төхөөрөмж, програм хангамж ДНТ-ээр сонгон шалгаруулж худалдан авах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

3.2.10 Цахим эрүүл мэндийн хэрэглээний програм боловсруулах ажлыг ДНТ-ээр сонгон шалгаруулж гүйцэтгүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажилтай нэгтгэгдсэн.

3.2.11. Сургалтын төвийн тоног төхөөрөмж ДНТ-ээр сонгон шалгаруулж худалдан авах *(бүтцийн өөрчлөлт хэсгийн 2.3.2)*

Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр байгуулагдах Дижитал эрүүл мэндийн сургалтын төвд авах тоног төхөөрөмж болон тавилгын жагсаалт, техникийн тодорхойлолтыг Дэлхийн банктай 2018 оны 10 сард хийгдсэн үнэлгээний үер тохирсон бөгөөд тендер шалгаруулалтын үнэлгээний хороо ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 сарын 19-ний өдрийн Б/395 тоот тушаалаар батлагдсан. ЭМХТ сургалтын танхимаар хангахаар болж, танхимын иж бүрэн засварыг 2018 оны 9 сард хийсэн. Дижитал эрүүл мэндийн сургалтын төв нь Дэлхийн банкнаас шаардсан чадавх бэхжүүлэх стратегитай уялдаж зохион байгуулагдах тул үнэлгээний хороо стратеги батлагдахаар хуралдах бэлтгэлээ хангаж байна. Дэлхийн банкнаас хэрэглэгчдийн анхан шатны сургалтын дотоодын зөвлөхийг энэ төвийг хариуцан ажиллуулахаар зөвлөсний дагуу ажлын удирдамжид оруулан батлуулсан. Үнэлгээний хороо хуралдах бэлтгэл ажил хангагдсан.

4.2.5 Оролцогч талуудын чадавх бэхжүүлэх (гадаад)

Энэ оны 2 дугаар сард Монгол Улсын Их Хурлын гишүүд, Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга, төслийн захирал, төслийн зохицуулагч, мэдээллийн технологийн мэргэжилтэн зэрэг 12 хүний бүрэлдэхүүнтэй баг Эстони улсад цахим эрүүл мэндийн туршлага судлах 5 хоногийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.

4.2.6 Оролцогч талуудын чадавх бэхжүүлэх (дотоод)

Эрүүл мэндийн шийдвэр гаргах, бодлого боловсруулагч ажилтнуудын чадавх бэхжүүлэх цахим эрүүл мэндийн сургалтыг 2-р сард ЭМЯ-тай хамтран амжилттай хамтран зохион байгуулсан.

Эрүүл мэндийн статистикийн мэргэжилтнүүдэд зориулсан цахим эрүүл мэндийн сургалтыг 9-р сарын 26-27-ны өдрүүдэд Корпорайт Конвеншн Центрт зохион байгуулсан. 21 аймгийн эрүүл мэндийн газар, 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, улсын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн статистикийн мэргэжилтнүүд, 21 аймаг, нийслэл, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн ажилтнууд нийтдээ 120 хүн оролцсон. Сургалтанд “Цахим эрүүл мэнд” төслийн талаас шинээр боловсруулж, мөрдүүлэх Цахим эрүүл мэндийн стандарт, журмын танилцуулга хийж, Иргэний ЭМ-ийн цахим бүртгэлийн системийн клиникийн өгөгдлийн уялдааг тайлбарлаж, Эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформын техникийн архитектурын шийдлийн талаар илтгэл тавьсан. Мөн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних журам”-ын төслийг танилцуулж, оролцогчдын санал зөвлөмжийг авсан. УБЕГ-ын талаас “Нэг иргэн – Нэг бүртгэл” Монгол улсын Засгийн газрын хөтөлбөр, “Төрөлт, нас баралтыг цахимаар бүртгэх системийн тухай”, “Төрөлтийн бүртгэлийн шинжилгээ”, ЭМД-ын цахим бүртгэлийн шинэ тогтолцоо, Өвчтөн шилжүүлэх журам зэрэг илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Эрүүл мэндийн анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын өөрчлөлтүүд, амбулаторт болон хэвтэн эмчлүүлэх тасагт хөтөлөгдөх шинэчлэгдсэн анхан шатны маягтын танилцуулгын хэлэлцүүлэг хийсэн. Дэлхийн Банкнаас бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерүүдийн сургалтыг 2020 онд хийхээр хойшлуулсан.

БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХЭСЭГ

1.1.1 ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийн гүйцэтгэгчийг

сонгон шалгаруулж гэрээ байгуулах

Цахим эрүүл мэнд төслийн нэгж ЭММСП боловсруулах, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, туршин нэвтрүүлэх олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичгийн төсөл болон ЭММСП-ын үзэл баримтлалыг 2018 оны 7 сараас боловсруулж, Дэлхийн банктай хэд хэдэн удаа зөвлөлдсөний үндсэн дээр 2018 оны 11 сарын 23-ны өдөр батлагдсан. Уг платформын тендер шалгаруулалтын үнэлгээний хороо ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 сарын 5-ны өдрийн Б/386 тоот тушаалаар 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, 2018 оны 11 сарын 30-ны өдөр хуралдсан. ЭММСП нь эрүүл мэндийн мэдээлэл солилцож, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын асуудал хөндөх тул ЭМЯ нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Тагнуулын ерөнхий газраас чиглэл авахаар 2018 оны 10 сарын 25-нд албан тоот илгээж, хариу 2018 оны 11 сарын 28-ны өдөр нууцын зэрэглэлтэйгээр Эрүүл мэндийн сайдад хүргэгдсэн. Уг тендер шалгаруулалт нь урьдчилсан сонгон шалгаруулалт бүхий нэг шаттай олон улсын нээлттэй тендер байна. Үнэлгээний хороогоор хэлэлцэж эцэслэсэн урьдчилсан сонгон шалгаруулалтын баримт бичгийг Дэлхийн банкинд 2018 оны 12 сарын 3-нд илгээж, зөвшөөрлийг 2018 оны 12 сарын 7-нд авсан. 2018 оны 12 сарын 11-нд урьдчилсан сонгон шалгаруулалтыг зарлах хүсэлтийг Дэлхийн банкинд илгээж, Дэлхийн банкны зөвшөөрөл 12 сарын 14-нд ирж, зарлал гаргасан.

1.1.4. ЭММСП-ын тоног төхөөрөмж ОУНТ-ээр худалдан авах

2018 оны 10 сард Монголд ирж ажилласан Дэлхийн банкны эрүүл мэндийн төслийн баг ЭММСП-ын тоног төхөөрөмжийн олон улсын нээлттэй тендер шалгаруулалтыг ЭММСП-ын хөгжүүлэлттэй уялдаж хийгдэх шаардлагатай гэсэн үндэслэлээр 2019 оны 2 дугаар хагасаас эхлүүлэх зөвлөмж өгч, тус тендер хойшилсон. Үндэсний дата төв одоо ашиглагдаж байгаа өгөгдөл хадгалах тоног төхөөрөмжтэйгөө нийцүүлж ажиллуулах үүднээс ЭММСП-ын тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг ЭМЯ-нд гаргаж өгөхөөр Дэлхийн банктай тохиролцсон.

1.1.7. HL7 олон улсын стандартын гишүүнчлэл, стандартууд авах

ТХН нь цахим эрүүл мэндийн чиглэлээр ашиглагддаг ISO, ASTM стандартуудыг судалж үзсэний үндсэн дээр 19 төрлийн стандартыг Стандартчилал, хэмжилзүйн газраар дамжуулан худалдан авах хүсэлтийг Дэлхийн банкнаас 2018 оны 11 сарын 12-нд авч, 2018 оны 12 сарын 7-нд стандартуудыг хүлээн авч ашиглаж байна. HL7 гишүүнчлэлийн бүртгэлийг онлайнгаар хийлгэсэн бөгөөд гишүүнчлэлийн төлбөрийг Дэлхийн банкны зөвшөөрөл хүлээж байна.

1.1.8. ЭММСП боловсруулж, хөгжүүлж, хэрэгжүүлэх ОУНТ-ийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах

ЭММСП хөгжүүлэх, нэвтрүүлэх, туршилтаар хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ОУНТ-ийн үнэлгээний хороо байгуулах ЭМЯ-ны ТНБД-ын тушаалын төслийг бэлтгэн ЭМЯ-д хүргүүлж, ТНБД-ын 2018 оны 11 сарын 5-ны өдрийн 5/386 тоот тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан.

1.2.2. Эрүүл мэндийн өгөгдлийн дотоодын зөвлөх үйлчилгээ авах

Боловсруулаад “Цахим эрүүл мэндийн стандартад санал дүгнэлт өгөх техникийн ажлын хэсгээр хэлэлцүүлсэн стандартууд:

- “Эрүүл мэндийн оролцогч талуудын ялган таних журам”
- “Иргэний Эрүүл Мэндийн Цахим бүртгэлийн систем байгуулах техникийн шаардлага”
- “Хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл”

“Цахим эрүүл мэндийн стандартад санал дүгнэлт өгөх техникийн ажлын хэсгээр хэлэлцүүлэхээр бэлэн болсон стандарт:

- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй мэдээлэл
- “Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хураангуй түүх”-ийн үндсэн өгөгдлийн бүтэц, техникийн шаардлага
- Цахим шилжүүлгийн журам

1.2.4. Эрүүл мэндийн өгөгдөл солилцооны стандартын дотоодын зөвлөх үйлчилгээ авах

“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних”, “ИЭМЦБ-ийн систем байгуулах техникийн шаардлага”, “Хэвтэн эмчлүүлсэн тухай тэмдэглэл өгөгдлийн бүтэц” стандартуудыг боловсруулалтын ажилд програм хангамж мэдээллийн технологийн

талаас нь хамтран ажилласан. Олон улсын ЭА-ын зөвлөхтэй хамтран Эстони улсын ИЭМЦБ систем дээр дараах сэдвийн хүрээнд ажилласан.

Үүнд:

- Үйлчлүүлэгчийн порталын хэрэглээ өгөдлийн бүтэц, хэрэглэгчийн интерфэйс
- Эмийн порталын хэрэглээ өгөдлийн бүтэц, хэрэглэгчийн интерфэйс
- ИЭМЦБ бизнес процессийн зураглал
- HL7 CDA бүтцүүдийн ашиглалт.

1.2.5. Цахим эрүүл мэндийн хууль эрх зүйн дотоодын зөвлөх хөлслөх, үйлчилгээ авах

Дотоодын зөвлөх сонгон шалгаруулах үнэлгээний хороо ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 3 дугаар сарын 26-ны өдрийн А/92 тоот тушаалаар байгуулагдаж, үнэлгээний хорооны 3-р сарын 27-ны өдрийн хурлаар дотоодын зөвлөхөд тавигдах шаардлагыг шинэчлэн баталсан. Дэлхийн банкны 4 дүгээр сарын 19-нд зөвшөөрөл олгож, 4 дүгээр сарын 24-нөөс “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонингуудаар зар түгээж, 5 дугаар сарын 8-нд 6 горилогчоос материал хүлээн авсан. Үнэлгээний хороо 5 дугаар сарын 11-ний өдөр хуралдан Н.Энхцэцэгийг шалгаруулсан. Дэлхийн банк зөвшөөрөл өгсөний дагуу гэрээ байгуулан 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн ажиллаж эхэлсэн. 11-р сарын 30-нд эхлэлтийн тайлан хүлээлгэн өгсөн.

1.3.1. Эрүүл мэндийн статистикийн дотоодын зөвлөхийн ажлын удирдамж боловсруулж, сонгон шалгаруулж, гэрээ байгуулах

2018 оны 10 сард Монголд ирж ажилласан Дэлхийн банкны ажлын баг Эрүүл мэндийн статистикийн дотоодын зөвлөхийн сонгон шалгаруулах ажлыг ЭММСП-ын хөгжүүлэлттэй уялдаатайгаар хийгдэх шаардлагатай гэсэн үндэслэлээр 2019 онд хөлслөхөөр Дэлхийн банкнаас шийдвэрлэсэн.

1.3.2. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг компьютерээр хангах ОУНТ-ээр 2 аймаг, 1 дүүргийн өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийг хангах

Цахим эрүүл мэнд төслийн нэгж анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хангах компьютер, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг 2018 оны 10 сард боловсруулж, тендер шалгаруулалтын үнэлгээний хороо ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 10 сарын 18-ны өдрийн

A/360 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж, 2018 оны 11 сарын 5, 13, 22-нд тус тус хуралдаж тендерийн баримт бичгийг батлан, Дэлхийн банкинд 2018 оны 12 сарын 12-нд илгээсэн, банкны зөвшөөрөл хүлээж байна. Дэлхийн банкнаас тендерийг 2018 оны 12 дугаар сард багтаан зарлах зөвшөөрөл өгөхөө урьдчилсан мэдэгдсэн.

2.1.1. Хэрэглэгчдийн мэдээллийн технологийн анхан шатны сургалтыг 2 аймаг, 1 дүүрэгт зохион байгуулах

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг компьютерээр хангах үйл ажиллагаатай хамтруулан 2019 оны 1 дүгээр улиралд хийхээр хойшлуулсан.

2.1.2. Хэрэглэгчдийн мэдээллийн технологийн анхан шатны сургалтын дотоодын зөвлөх сонгон шалгаруулж, гэрээ байгуулах

ТХН нь анхан шатны сургалтын дотоодын зөвлөхүүдийн ажлын удирдамжийг 2018 оны 7 сард боловсруулж, зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 7 сарын 24-ний өдрийн А/261 тоот тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 2018 оны 5 сард хийгдсэн төслийн дунд хугацааны үнэлгээний үр дүнд төслийн бүтцийн өөрчлөлт хийгдэж, уг зөвлөхийн сонгон шалгаруулалтыг санхүүжилтийн хэлэлцээрт хийх нэмэлт өөрчлөлт батлагдсаны дараа эхлүүлэх зөвлөмжийг Дэлхийн банк өгсөн. Санхүүжилтийн хэлэлцээрийн нэмэлт өөрчлөлт 2018 оны 10 сарын 1-нд батлагдаж, Дэлхийн банкнаас чадавх бэхжүүлэх стратегийг боловсруулах шаардлагыг 2018 оны 10 сард өгсний дагуу стратегийг 2018 оны 10 сарын 31-нд илгээсэн. Дэлхийн банкнаас чадавх бэхжүүлэх стратегийг мөрдөж ажиллахыг 12 дугаар сарын 17-нд зөвшөөрсөн. Зар гаргах зөвшөөрөл Дэлхийн банкнаас хүлээж байна.

2.1.3. Хэрэглэгчдийн мэдээллийн технологийн ахисан шатны сургалтын дотоодын зөвлөх сонгон шалгаруулж, гэрээ байгуулах

ТХН нь анхан шатны сургалтын дотоодын зөвлөхүүдийн ажлын удирдамжийг 2018 оны 7 сард боловсруулж, зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь ЭМЯ ТНБД-ын 2018 оны 7 сарын 24-ний өдрийн А/261 тоот тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 2018 оны 10 дугаар сард Дэлхийн банкны эрүүл мэндийн төслийн багийн

өгсөн зөвлөмжийн дагуу сургалтын зөвхөн нэг дотоодын зөвлөх хөлслөхөөр шийдвэрлэсэн.

2.1.4. Мэдээллийн технологийн анхан шатны сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, хэвлүүлэх

Дэлхийн банкны зөвлөмжөөр төслийн бүтцийн өөрчлөлтөд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг компьютерээр хангах үйл ажиллагаатай хамтруулан 2019 оны эхний хагас жилд хийхээр төлөвлөсөн.

2.1.10. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг CISCO аюулгүй байдлын 30 хоногийн сургалтад хамруулах

2018 оны 10 дугаар сарын 15-наас 20-ны хооронд Монгол Улсад ирж ажилласан Дэлхийн банкны эрүүл мэндийн төслийн багаас өгсөн чиглэлийн дагуу Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг CISCO аюулгүй байдлын 30 хоногийн сургалтад хамруулах ажлыг хойшлуулж, ЭММСП-ын тендерийг зарласны дараа, уг сургалтанд хамрагдах мэргэжилтнүүдтэй ЭМЯ тогтвортой ажиллах гэрээ байгуулсаны дараа хийх чиглэл өгсөн. Төслийн цахим эрүүл мэндийн зөвлөхөөс ЭММСП-ыг нэвтрүүлсэний дараа, ЭММСП-ын гэрээг гүйцэтгэгчээс зохион байгуулах сургалтуудад хамруулсаны дараа уг сургалтыг хийх зөвлөгөө өгсөн. ТХН-ийн зүгээс CISCO академийн сургалтыг Монгол Улсад зохион байгуулж, гэрчилгээ олгодог сургалтын байгууллагуудын судалгааг хийж, сургалтын хөтөлбөр боловсруулан, өртөг зардлыг тооцоолон төсөвт суулгасан.

2.1.12. Хэрэглэгчдийн мэдээллийн технологийн сургалт хийх байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах

Дэлхийн банкнаас аймаг тус бүрээс 3 сургагч багш сонгож, хэрэглэгчдийн мэдээллийн технологийн анхан шатны болон ахисан түвшний сургалтын сургагч багш бэлтгэхээр шийдвэрлэж, сургалт хийх байгууллага сонгон шалгаруулахгүй болсон. Сургагч багш бэлтгэх сургалтыг 2019 оны 1 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн.

2.2.1. Өрх, сумын ЭМТ-үүдийг өндөр хурдны интернэтэд холбох

Өрх, сумын ЭМТ-үүдийг өндөр хурдны интернэтэд холбох талаар төслөөс урьд нь хийж байсан судалгаагаа сайжруулан ЭМЯ, Мэдээлэл, холбооны сулжээ ТӨҮК, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Увс, Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газруудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдтэй

уулзан хэрэгцээ шаардлагын судалгааг нарийвчлан гаргасан. ЭММСП-ын гэрээний гүйцэтгэл эхлэх үеэр дээрх туршилтын байгууллагуудыг үндэсний өндөр хурдны өгөгдлийн сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангасан.

2.2.2. Төслийн туршилтын байгууллагуудын интернэт төлбөр хийх

Увс, Хөвсгөл аймаг, Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч анхан шатны байгууллагуудын интернет төлбөр хийх тооцоог гаргаж, Дэлхийн банкинд зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. Дэлхийн банкнаас интернетийн төлбөр хийхийг зөвшөөрөхгүй гэж мэдэгдсэн тул улсын төсөвт тусгахаар ЭМЯ-ны холбогдох ажилтнуудтай ярилцаж тохиролцсон.

2.2.3. ЭММСП-ын гэрээний хяналт хийх дотоодын зөвлөх (4 хүн/сар, 1,000 ам доллар) хөлслөх

ЭМЯ-наас Төслийн дунд хугацааны хяналтын үеэр Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтсийн дэргэд гуравдах шатлалын эмнэлэг бүрээс нэг нэг мэргэжилтэн ажиллуулах замаар, эмнэлгийн мэргэжилтнүүдийн баг ажиллуулахаар тус хэлтсийн дарга санал гаргасан. Дэлхийн банкны баг уг хүсэлттэй танилцаад, ТХН ажиллаж байгаа тул дахиж төслийн баг ажиллуулах боломжгүй гэж үзээд хоёр орон тоо баталсан. ЭМЯ-ны Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтэс ЭММСП-ын тендерийн ажлын гүйцэтгэлийн явцад удирдамжийг боловсруулахаар тохиролцсон. (60%)

2.2.4. Чадавч бэхжүүлэх үйл ажиллагаа (гадаад-Сингапур)

ТХН-ээс гадаад сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулж, оролцогчдын жагсаалтыг гарган зөвшөөрөл авахаар Дэлхийн банкинд хүргүүлсэн. Дэлхийн банкнаас 2019 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

2.2.5.1 Улсын 48 эмнэлгийн статистикч нарын 3 хоногийн цахим эрүүл мэндийн сургалт зохион байгуулах

Эрүүл мэндийн статистикийн мэргэжилтнүүдэд зориулсан цахим эрүүл мэндийн сургалтыг 9-р сарын 26-27-ны өдрүүдэд Корпорайт Конвеншн Центрт зохион байгуулсан. 21 аймгийн эрүүл мэндийн газар, 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, улсын төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн статистикийн мэргэжилтнүүд, 21 аймаг, нийслэл, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн ажилтнууд нийтдээ 120 хүн оролцсон. Сургалтанд “Цахим эрүүл мэнд” төслийн талаас шинээр

боловсруулж, мөрдүүлэх Цахим эрүүл мэндийн стандарт, журмын танилцуулга хийж, Иргэний ЭМ-ийн цахим бүртгэлийн системийн клиникийн өгөгдлийн уялдааг тайлбарлаж, Эрүүл мэндийн мэдээлэл солилцох платформын техникийн архитектурын шийдлийн талаар илтгэл тавьсан. Мөн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд оролцогч талуудыг ялган таних журам”-ын төслийг танилцуулж, оролцогчдын санал зөвлөмжийг авсан. УБЕГ-ын талаас “Нэг иргэн – Нэг бүртгэл” Монгол улсын Засгийн газрын хөтөлбөр, “Төрөлт, нас баралтыг цахимаар бүртгэх системийн тухай”, “Төрөлтийн бүртгэлийн шинжилгээ”, ЭМД-ын цахим бүртгэлийн шинэ тогтолцоо, Өвчтөн шилжүүлэх журам зэрэг илтгэлүүдийг хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Эрүүл мэндийн анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын өөрчлөлтүүд, амбулаторт болон хэвтэн эмчлүүлэх тасагт хөтөлөгдөх шинэчлэгдсэн анхан шатны маягтын танилцуулгын хэлэлцүүлэг хийсэн.

2.2.5.2 Улсын 48 эмнэлгийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн 3 хоногийн цахим эрүүл мэндийн сургалт зохион байгуулах

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв, ЭМХТ, ЭМЯ-ны мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд зориулсан 2 хоногийн эрчимтэй сургалтыг зохион байгуулахаар бэлтгэн сургалтын хөтөлбөр, төсөв, сургалтын удирдамжуудыг бэлтгэн 2018 оны 12 дугаар сарын 5- 6, 7-8 өдрүүдэд хийлгэх төлөвлөгөөтэй байсан боловч ЭМЯ-наас 12 дугаар сард сургалт хийхгүй гэсэн чиглэл өгсөн тул 2019 оны 1 улиралд хийхээр хойшлуулсан. Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээний мэргэжлийн сургалт зохион байгуулдаг газруудын судалгаа, үнийн судалгаа, сургалт явуулах анги, танхим, сургагч багш, сургалтын танхимын тоног төхөөрөмж, компьютерийн хангамж зэрэг сургалттай холбоотой судалгаа авч, дүгнэн, сургалт зохион байгуулах газартай тохиролцсон, зөвхөн ЭМЯ-наас сургалт хийх хугацаа товлож өгөхийг хүлээж байна.

2.2.5.3 Олон нийтийг хамруулсан сурталчилгаа хийх

Олон нийтэд төслийн талаар мэдээлэл түгээх зорилгоор “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилт, хүрэх үр дүнг харуулсан богино хэмжээний (3 минут) танилцуулга видео бичлэгийг Сангийн яаманд 2018 оны 6 сард бэлтгэж хүргүүлсэн.

2.3.1. Компьютерийн сургалтын төв, онлайн сургалтын дотоодын зөвлөх сонгон шалгаруулж, хөлсөөр ажиллуулах

Дэлхийн банкнаас сургалтын зөвхөн нэг дотоодын зөвлөх хөлслөхөөр шийдвэрлэсэн тул ажил үүргийн хуваарийг “Компьютер хэрэглэгчийн сургалтын дотоодын зөвлөх”-ийн ажлын удирдамжтай нэгтгэсэн. Энэ дотоодын зөвлөхийн ажлын удирдамжийг 2018 оны 7 сард боловсруулж, зөвлөхийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо нь ЭМЯ-ны ТНБД-ын 2018 оны 7 сарын 24-ний өдрийн А/261 тоот тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Сургалтын дотоодын зөвлөхийг зарлах зөвшөөрлийг Дэлхийн банкнаас хүлээж байна.

2.3.5. Сургалтын төвийн тохижилт засвар

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс “Дижитал эрүүл мэндийн сургалтын төв” байрлуулах өрөөг гаргаж, төсвийн хөрөнгөөр засварыг хийж гүйцэтгэсэн.

3.1. Төслийн холбогдох мэдээллийг сайтуудад байршуулсан байх

Шилэн данс, ОДАМИС зэрэг сайтуудад мэдээллийг хугацаанд нь байршуулсан.

3.2. Орон нутагт томилолтоор ажиллах

Дэлхийн банкны эрүүл мэндийн төслийн багийнхантай хамт Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Адаацаг сумын эрүүл мэндийн төвд ажилласан.

3.3. Төслийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан улирал тутамд гаргаж, ТУХ-ны гишүүдэд тараах

“Цахим эрүүл мэнд” төслийн хяналт-шинжилгээ үнэлгээний улирлын тайланг төслөөс Сангийн яамны 2015 оны 196 дугаар тушаалын 10 дугаар хавсралтын загварын дагуу боловсруулан Төслийн Захиралд танилцуулан зөвшөөрөл авч, 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын “Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/524 тоот тушаалаар батлагдсан удирдах хорооны гишүүдэд цахим шуудангаар, Удирдах хорооны дарга, эрүүл мэндийн байд болон төслийн захирал нарт албан бичгээр улирал тутам хүргүүлж хэвшсэн.

Төслийн санхүүгийн удирдлага:

Төслийн санхүүгийн удирдлагын системийг Дэлхийн банкны санхүүгийн бүртгэл, Улсын секторын Нягтлан бодох бүртгэл(НББ)-ийн журам, төсөвт байгууллагын НББ-ын суурилан мөнгөн сууриар мөнгөн

хөрөнгийн нөөцөд суурилан бүртгэгдэж Дэлхийн банкинд улирал бүр ам доллараар , ЭМЯ-нд хагас бүтэн жилээр төгрөгөөр санхүүгийн тайланг гаргаж өгдөг. Дэлхийн банкны Төслийн дунд хугацааны үнэлгээний дүгнэлтээр Төслийн санхүүгийн үйл ажиллагаа "Хангалттай" Үндэсний аудитын газар, Дэлхийн банк Төслийн гурвалсан гэрээгээр хийгддэг жил бүрийн аудитаар "Зөрчилгүй" гэсэн дүгнэлтийг авч ажилласан.

Тайлант хугацаанд нийт өссөн дүнгээр 872 115.22 ам долларын зарцуулалтыг хийж ажилласнаас нэг ба хоёр дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 429 864.24 ам доллар, гурав дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 442 251.03 ам долларын зарцуулаад байна.

2018 онд Дэлхийн банкнаас нөхөн дүүргэлтээр нийт 462 426.22 ам долларын санхүүжилтийг авч тусгай дансанд татан төвлөрүүлэн журмын дагуу зарцуулан ажилласан.

2018 онд “Цахим эрүүл мэнд” төслийн төлөвлөсөн үйл ажиллагааны биелэлт 84.1 хувь байна.

“Цахим эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлэх нэгж.